



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2007 оны 01 дугаар  
сарын 08 -ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Дүрэм, орон тоог батлах  
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Боловсролын газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Боловсролын газрыг "Боловсролын төв"-тэй, орон тооны хязгаарыг 27 хүртэл байхаар тогтоосугай.

Гурав. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулах ажлыг зохион байгуулахыг Боловсролын газар /П.Дорж/-т даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/57 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны  
*08 дугаар* захирамжийн хавсрагт

## БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын газар нь /цаашид “газар” гэх/ нийслэлийн нутаг дэвсгэрт сургуулийн насны хүүхдийг бүх нийтээр хамруулан сургах, хүүхэд залуучуудад шинжлэх ухааны үндсэн мэдлэгийг эзэмшүүлэх, тэднийг бүх талаар хөгжүүлэн хүмүүжүүлэх, иргэдийн ерөнхий боловсролын түвшинг байнга дээшлүүлэх, сургалт хүмүүжлийн ажлын материаллаг баазыг бэхжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжууд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тогтоол, шийдвэр, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь Нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.4. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж, чөлөөлнө.

1.5. Газрын дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

1.6. Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

1.7. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.8. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батлана.

1.9. Газар нь дэргэдээ Боловсролын төвтэй байх бөгөөд төвийн захиралыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлнө. Төвийн арга зүйчдийг газрын даргын тушаалаар томилж, чөлөөлнө.

1.10. Боловсролын төв нь нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх боловсролын бодлогыг боловсруулах, хэрэгжилтийг хянаж дүгнэх, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн сургалт хүмүүжлийн ажилд арга



зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй бөгөөд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны баталсан дүрмийн дагуу ажлаа явуулна.

### **Хоёр. Газрын үүрэг**

2.1. Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2. Холбогдох хууль тогтоомж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

2.3. Нутаг дэвсгэртээ ерөнхий боловсрол олгох болон сургуулийн өмнөх насны хүүхдийн ба сургуулиас гадуур хүмүүжил олгох байгууллагыг удирдаж, сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт хамруулах, сургуульд бэлтгэх, сургуулийн насны хүүхдэд суурь боловсрол, ёс суртахуун, бие бялдар, гоо зүйн хүмүүжил олгох ажлыг зохион байгуулах.

2.4. Нутаг дэвсгэртээ ерөнхий боловсролын дунд сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн болон сургуулиас гадуур хүмүүжил олгох байгууллагыг зохистой байршуулж, тэдгээрийн үйл ажиллагаанд харъяалал харгалзахгүйгээр хяналт тавих.

2.5. Ерөнхий боловсролын дунд сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн болон сургуулиас гадуур хүмүүжил олгох байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, сургууль үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх, сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгон амьдрах ухаанд сургах, түгээмэл мэргэжил эзэмшүүлэх, сурагчдын хөдөлмөр сургалтад төр захиргаа, аж ахуйн нэгж, байгууллагын цех тасгийг ашиглах ажлыг зохион байгуулах.

2.6. Ерөнхий боловсролын оройн ээлжийн болон эцнээ сургалтын чанарыг сайжруулах, зохих шатны боловсрол эзэмшээгүй залуучуудыг сургуульд бүрэн хамруулан суралцах бололцоогоор хангах.

2.7. Сургалтын лаборатори, кабинет, мастерын газрыг тогтоосон журмын дагуу байгуулах, хичээлийн хэрэглэл, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материал, техник хэрэгсэл, сурах бичгийг захиалах, хуваарилах ажлыг зохион байгуулж, ашиглалтанд нь хяналт тавих.

2.8. Нийслэлийн зарим дүүргийн малчдын хүүхдийг дотуур байраар хангаж, сурагчдын дотуур байрыг тохижуулах, сурагчдын хоолыг амт чанар сайтай байлгах ажлыг зохион байгуулж хяналт тавих.

2.9. Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах бодлогыг Эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлэх.

2.10. Сургуулийн өмнөх насны хүүхдийн болон сургуулиас гадуур хүмүүжил олгох байгууллагыг бэхжүүлэх, нутаг дэвсгэрийн нөөц бололцоог ашиглаж, хүүхдийн цэцэрлэг, сургууль, хүмүүжлийн төв, тоглоомын талбай, хотхон, уншлагын ганхим зэргийг байгуулах ажлыг зохион байгуулах.

2.11. Ерөнхий боловсролын болон хүүхдийн цэцэрлэгийн асуудлаар үзэсгэлэн, хурал, семинар зөвлөлгөөн болон биеийн тамир, урлаг спортын тэмцээн, уран бүтээлийн уралдаан, тойрон аялал, төрөл бүрийн олимпиад зохион байгуулах.

2.12. Сурагчдын хичээл, үйлдвэрлэлийн дадлагын үед хөдөлмөр хамгааллын дүрэм, зааврыг чанд мөрдүүлэх.

2.13. Өнчин болон асрах хүнгүй хүүхдэд асран хамгаалагч харгалзан дэмжигч томилуулах, эдгээр ясли, цэцэрлэг, дотуур байртай сургуульд оруулах, асрамжийн газарт шилжүүлэх, хүүхдийг хараа хяналтгүй байлгах явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авч байх.

2.14. Нийслэлийн дүүрэг, хороодоос боловсролын салбарыг удирдах талаар зохиож байгаа ажилд хяналт тавьж, зохих удирдлагаар хангах санал, дүгнэлт өгөх.

2.15. Багш, сурган хүмүүжүүлэгчид, иргэдийн санал, өргөдөл гомдлыг хүлээн авч хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэн, шаардлагатай мэдээ судалгааг холбогдох газарт гаргаж байх.

2.16. Эцэг эх, тэднийг төлөөлөх хүмүүсээс үр хүүхдээ хүмүүжүүлэхэд нь сурган хүмүүжүүлэх мэргэжлийн туслалцаа үзүүлж байх.

2.17. Сургууль, цэцэрлэгт олгосон хөрөнгө оруулалтыг зөв зохистой хуваарилаж, барилга байгууламжийн их засварыг холбогдох газартай хамтарч шийдвэрлэх.

2.18. Шинээр байгуулагдаж байгаа сургуульд тусгай зөвшөөрөл гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлыг нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх.

2.19. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр нийслэлийн засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах.

2.20. Байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

2.21. Эрхэлж буй ажлын хүрээнд холбогдох зайлшгүй шаардлагатай асуудлаар асуудал боловсруулан Засаг даргад оруулж шийдвэрлүүлэх.

2.22. Нийслэлийн хэмжээнд сургуулийн насанд хүрэх болон сургуулийн насны хүүхдийн бүртгэл судалгааг гаргасны үндсэн дээр сургуулийн суудал,

багш, сурах бичгийн хангалт, хамран сургалт, сургалтын чанарыг ахиулах, сургууль завсардалтыг бууруулах арга хэмжээг авч байх.

### **Гурав. Газрын эрх**

3.1. Сургууль, хүүхдийн байгууллагуудын зохион байгуулалт, бүтцийг батлах, тэдгээрийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх.

3.2. Харьяа байгууллагуудын удирдах албан тушаалтныг томилоход /ЕБС-ийн захирал, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч болон бусад/ санал өгөх, тэдний ажлын талаар томилсон байгууллагад нь саналаа оруулах.

3.3. Сургууль, хүүхдийн байгууллагуудын үйл ажиллагааны жил, хэтийн зорилт, төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, газрын батлагдсан төсвийг захиран зарцуулж тайлагнах.

3.4. "Боловсролын сан"-г хот, дүүрэгт зохих журмын дагуу байгуулах, сангийн зарцуулалтыг холбогдох газарт шалган зааварлах.

3.5. Боловсролын талаар гаргасан эмхтгэл, гарын авлага, зөвлөмжийг хэвлэн нийтлүүлэх.

3.6. Боловсролын газрын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, холбогдох байгууллагад тавих.

3.7. Боловсролын талаар төсөл хэрэгжүүлэх ажилд оролцох.

3.8. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.9. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх.